



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

□ Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай □

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.3 дахь заалт, “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК-ийн 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 07/16 дугаар албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 230 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Тус үнэт цаасны компанийн ирүүлсэн саналыг харгалзан гишүүнчлэлийн хөлсийн нийт өр барагдуулах хугацааг 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоож, үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээ шууд авахыг “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК /С.Гантулга/-д анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР

000062